

БАТЛАВ:

АШУҮИС-ИЙН ЭРДМИЙН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Н.СҮМБЭРЗУЛ

АШУҮИС-ийн Эрдмийн чуулган-64 эрдэм шинжилгээний хурлын

Эрдмийн сургуулийн салбар хурлын удирдамж

2022 оны 02 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

АШУҮИС-ийн 80 жилийн ойд зориулсан “Эрдмийн Чуулган-64” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах тухай АШУҮИС-ийн захирлын 2022 оны 02-р сарын ... өдрийн ... тоот тушаалд үндэслэн Эрдмийн сургуулийн салбар хурлыг 2022 оны 04-р сарын 07-ны өдөр зохион байгуулна.

Хурлыг Монгол Улсын Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогод нийцүүлэн эрүүл мэндийн салбарын инноваци, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийн хүрээнд нотолгоонд суурилсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр болон Эрдмийн сургуулийн эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлээр хийгдсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн бүхий шилдэг илтгэлүүдийг хэлэлцэгдэхээр зохион байгуулна.

**Зохион байгуулагч:**

АШУҮИС-ийн Эрдмийн сургууль

**Хугацаа:**

2022 оны 04-р сарын 07-ны өдөр

**Хурал зохион байгуулах хэлбэр**

Цахим

**Хамрах хүрээ:**

- Анагаах ухаанаар боловсрол олгох их, дээд сургуулиуд
- Монгол Улсын бүх шатлалын эмнэлгүүд
- Эрүүл мэндийн бусад байгууллагууд

**Хэлэлцэх сэдэв:**

Нотолгоонд суурилсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх, цахим боловсрол судлал, глобал эрүүл мэнд, эмнэлгийн чанар, аюулгүй байдал, менежмент, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжил болон эмч, анагаах ухааны эрх зүй, эрүүл мэндийн мэдээллийн технологи

**Илтгэлийн хураангуйд тавигдах шаардлага:**

Илтгэлийн хураангуйг А4 цаасан дээр, бүх талаас 2 см зайтай, Arial 11 үсгийн фонтоор, мөр хоорондын зай 1.5 , 4 талаас тэгш (Justify) байхаар монгол хэлээр, 300 үгэнд багтаах ба эх бичвэрийг бичихдээ догол мөрнөөс (tab-1cm) эхэлж бичнэ. Хураангуй дараах бүтэцтэй байна. Үүнд:

*Бүтээлийн сэдэв:* Arial 12, Bold, том үсгээр (UPPERCASE) бичигдэнэ. Дэд гарчиг нь 12 pt (size) хэмжээтэй, зүүн

талруу (align left) шахсан байна.

*Судлаачдын нэрс, харьяалал:* Илтгэлийн нэрийн баруун дор Arial 11 фонтоор Italic горимоор бичигдэнэ. Үндсэн судлаачтай холбогдох цахим шуудангийн хаяг, утасны дугаарыг бичсэн байна.

*Үндэслэл:* 1-2 өгүүлбэрт багтаан бичнэ.

*Судалгааны зорилго, зорилт:* Тус бүрийг нэг өгүүлбэрээр илэрхийлнэ

*Судалгааны материал, арга зүй:* Судалгаанд хэрэглэсэн арга зүйг тодорхой илэрхийлнэ.

*Үр дүн:* Хүснэгт, зураг оруулахгүй гол үр дүнг хураангуйлан бичнэ.

*Дүгнэлт:* 1-2 өгүүлбэрт багтаан илэрхийлнэ.

*Түлхүүр үгс:* Тухайн судалгааны онцлог, агуулгыг илэрхийлэх 5 хүртэл үг байна.

*Жич:* Өгүүлэл хэвлүүлэх бол ЭМШУ сэтгүүлд тавигдах шаардлагын дагуу бэлтгэн илгээнэ.

**Материал хүлээн авч  
дуусах хугацаа:**

2022 оны 04-р сарын 01-ний өдрийн 17 цаг хүртэл хүлээн авна.

**Материал хүлээн авах хаяг:  
Дэлгэрэнгүй мэдээллийг  
лавлах утас  
Төлбөр**

grad.ac@mnums.edu.mn

976-9919-0348

Нэг хураангуй 20,000 төгрөг, өгүүлэл бол нүүр тус бүр 10,000 төгрөгөөр тооцно.

Эрдмийн сургуулийн Хаан банк 5431143942 тоот дансанд хийнэ.

Гүйлгээний утга дээр Эрдмийн чуулган-64 Нэгдүгээр авторын нэрийг бичээд баримтаа хураангуйн хамт илгээнэ.

## ЭРДМИЙН ЧУУЛГАН-64

### Эрдмийн сургуулийн салбар хуралдаан

#### зохион байгуулах ажлын төлөвлөгөө

№	Арга хэмжээ	Хариуцсан багш, аргазүйч	Хугацаа
1	Хурлын зар, урилгын эхийг бэлтгэн хянуулж, мэдээллийн хэрэгслээр түгээх	Э.Ренчиндорж Г.Баясгалан	2022.02.15-нд мэдээллийг хүргэсэн байна.
2	Хурлын илтгэлийн хураангуйг хүлээн авч, хянан магадлан, хэвлэлд бэлтгэх	Ц.Сарнай Ц.Мөнхтуяа	2022.04.01 хүлээн авч дуусна 2022.04.03 хэвлэлийн эхийг бэлтгэж өгнө.
3	Эмхэтгэлийг хэвлүүлэх	А.Номин	2022.04.05-нд хэвлүүлсэн байна.
4	Хурлын хөтөлбөр боловсруулан, эхийг бэлтгэн хэвлүүлэх	О.Болорсайхан	2022.04.05-нд хэвлүүлсэн байна.
5	Хурлын заалыг бэлтгэх	Ё.Мөнхзул Э.Ганбат	2022.04.06 Бэлтгэлийг шалгуулах 2022.04.07 Бэлэн байдлыг хангаж ажиллана.
6	Хурлын дэг боловсруулах	Б.Мөнхбат	2022.04.06 нд Хурлын дарга, НБДарга нарт өгсөн байна.
7	Хурлын холболт, инженеринг	Г.Лхагвасүрэн А.Аварзэд	2022.04.06 Бэлтгэлийг шалгуулах, 2022.04.07 Бэлэн байдлыг хангаж ажиллана.
8	Төсөв боловсруулж, ивээн тэтгэгч олох, шагнал бэлтгэх	Э.Ганбат Ч.Батсүрэн Ц.Сарнай	2022.04.01
9	Мандатын эх бэлтгэн, хэвлүүлэх, зүүхэд бэлтгэх	Г.Хулан	2022.04.01
10	Хурлын өдөр ерөнхий координац хийх	Б.Мөнхбат Ц.Сарнай	2022.04.06 Бэлтгэлийг шалгуулах 2022.04.07 Бэлэн байдлыг хангаж ажиллана.